

провокационной манеры ношения палок резиновых пенитенциарным персоналом. Подобная практика в деятельности ИУ была исключена указанием ГУИН МЮ РФ от 26.11.2002 года № 18/6/2-621, которое определило порядок ношения специальных средств. По нашему мнению решением данной проблемы должно стать непосредственное обеспечение сотрудников учреждений УИС скрытно носимыми электрошоковыми устройствами, а так же телескопическими вариантами палки резиновой, которые можно носить скрытно.

Не стоит забывать, что служебная деятельность сотрудника УИС основана на строгом соблюдении нормативно-правовых актов, а следовательно, внедрение и последующее использование описанных в данной научно статье средств обеспечения безопасности персонала УИС будет возможно только после соответствующего их правового закрепления в нормативных актах.

Подводя итог, стоит сказать, что работа по поддержанию правопорядка и соблюдению законности в ИУ это сложный и многоаспектный вопрос, в котором безопасность персонала ИУ должна стоять на первом месте. Дальнейшее совершенствование инженерно-технических средств надзора и охраны, их своевременное внедрение и достаточная обеспеченность ими сотрудников ИУ позволит существенно повысить безопасность УИС

\* \* \*



## Ц.ОЧГЭРЭЛ

ХСИС-ийн Эрдэм шинжилгээ, хөгжлийн хүрээлэнгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлалын төвийн эрхлэгч, хурандаа

### ХОРИХ БАЙГУУЛЛАГААС СУЛЛАГДАГСДЫГ НИЙГЭМШҮҮЛЭХ ШААРДЛАГА, ТОГТОЛЦООНЫ ШИНЭЧЛЭЛ

Холбогдох хаяг: утас: -

99837000 [ochgerel\\_mn@yahoo.com](mailto:ochgerel_mn@yahoo.com)..

**Түлхүүр үгс:** Хорих ял, хорих ангиас суллагдагсад, гэмт зан үйл, нийгэмшүүлэх, пробаци, хууль сахин биелүүлэх, нийгэмд дасан зохицох.

**Хураангуй:** Нийгэмд аюултай үйлдэл, эс үйлдэл буюу Монгол Улсын хууль, тогтоомжид заасан гэмт хэрэг үйлдэн хорих ял эдэлж улмаар суллагаад дахин гэмт хэрэг үйлдэж хорих ялаар шийтгэгдэгсэдийн тоо буурахгүй байгаа өнөөгийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийх, суллагдагсдыг нийгэмшүүлэх асуудлыг эрх зүйн зохицуулалт болон тогтолцооны шинэчлэлийн үүднээс авч үзсэн.

### Оршил

Монгол Улсад нийгэм, эдийн засгийн тогтолцооны өөрчлөлт хийгдсэнээс хойш тодорхой хугацаа өнгөрч байгаа боловч нийгмийн харилцаа, хууль, эрх зүйн болон хууль сахиулах салбарт хийгдэж буй, хийгдэх шаардлагатай өөрчлөлтүүд үргэлжилж байна. Иргэдийн амьдралын хэв маяг, хүний харилцааны шинж байдал өөрчлөгдөж, техник, технологийн салбарын хөгжил, эдийн засаг, улс төрийн тогтолцооны салбарт явагдаж

буй өөрчлөлтүүд нь улс орны дотоод нөхцөл байдал, нийгмийн амьдралд эерэг болон сөрөг үр нөлөөг үзүүлсээр байна. Түүнчлэн олон улсын эдийн засаг, улс төр, геополитик, цэрэг дайны бодлого үлэмж хэмжээгээр хувьсан өөрчлөгдөж байгаа өнөөгийн нөхцөлд нийгмийн аюулгүй байдалыг хангаж, хүний хөгжлийг дэмжихэд чиглэсэн эрх зүйн салбарын болон тогтолцооны шинэтгэлийг шийдвэртэйгээр хийх шаардлагатай байна.

Үндсэн Хуулиндаа "... эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгмийг цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилго болгоно"<sup>134</sup> хэмээн зарлан тунхаглаж баталгаажуулсан манай улсын хувьд хууль эрх зүйн болон нийгмийн ухааны бүхий л салбар нь хүний хөгжлийг, нийгмийн зөв тогтолцоог дэмжин хөгжүүлж, хүн бүр эрүүл аюулгүй орчинд амьдрах баталгааг бий болгох явдал юм.


Нийгмийн харилцаа, тэр дундаа хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, нийгмийн амьдралыг зохицуулах, шударга ёсыг сэргээн тогтоох зорилго бүхий эрх зүйн салбар шинжлэх ухаанууд нь дээрх зорилтыг хангахад үзэл баримтлалаа уялдуулан хөгжих нь зүйн хэрэг юм. Өөрөөр хэлбэл иргэдийн болон нийгмийн аюулгүй байдлыг хангах зорилгын үүднээс авч хэрэгжүүлж буй эрх зүйн шинэчлэл, төрийн байгууллагуудын зүгээс хэрэгжүүлж буй бодлого, үйл ажиллагаа нь Үндсэн Хуулийн дээрх заалтыг тулгуур болгон баримталсан байвал зохино. "Төр нь ардчилсан нийгэмд байдаг хүний эрхийг хангахдаа эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон

бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцана гэж тухайлан заасан юм."<sup>135</sup>

Дээрх бүгдтэй уялдуулан судлаач нь энэ удаагийн асуудал дэвшүүлсэн илтгэлээрээ өнөөгийн нийгэмд тулгамдсан асуудлуудын нэг болох хорих ял эдлээд суллагагсадыг нийгэмшүүлэх асуудал, түүний эрх зүйн зохицуулалт, төрийн байгууллагуудын уялдаа холбоо, тогтолцооны шинэчлэлийн асуудлаар саналаа дэвшүүлж байна.

Хэдийгээр хорих ял эдлэгсдийг нийгэмшүүлэх, тэдгээрийг эргэн нийгмийн амьдралд хууль сахин биелүүлэгч зөв иргэн болгон төлөвшүүлж оруулах асуудал нь судлаач эрдэмтэдийн анхаарлыг татсаар ирсэн боловч гадаад улс орнуудын жишигийг судлан нэвтрүүлэх, зохистой эрх зүйн зохицуулалт, тогтолцооны шинэчлэл хийх бодит шаардлага байсаар байна.

Нийт бүртгэгдсэн гэмт хэргийн тоо



<sup>134</sup> "Монгол Улсын Үндсэн Хууль" Улаанбаатар 1992 он. Албан ёсны хэвлэл 3 дах тал.

<sup>135</sup> Б.Чимид "Үндсэн хуулийн үзэл баримтлал: Хүний эрх, шүүх эрх мэдэл" Улаанбаатар 2004 он 17 дахь тал.

## МОНГОЛ УЛСЫН ГЭМТ ХЭРГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ БА ХОРИХ ЯЛ ЭДЛҮҮЛЭХ АЖИЛЛАГАА, СУЛЛАГДАГСАДЫГ НИЙГЭМШҮҮЛЭХ ШААРДЛАГА

### Улсын хэмжээнд үйлдэгдэж буй гэмт хэргийн үзүүлэлт

Сүүлийн жилүүдэд улсын хэмжээнд үйлдэгдэж буй гэмт хэргийн үзүүлэлт өсөх хандлагатай байгаагийн зэрэгцээ, гэмт үйлдлийн арга, хэлбэр нарийсч, илүү харгис, зохион байгуулалтай шинжтэй болсоор байна.

Юуны түрүүнд улсын хэмжээнд үйлдэгдэж байгаа гэмт хэргийн тоон үзүүлэлтийг авч үзвэл сүүлийн гурван жилийн байдлаар гэмт хэргийн тоо, түүний улмаас хохирсон иргэдийн тоо өссөөр байна. Зөвхөн 2014 оны байдлаар гэмт хэргийн улмаас иргэд байгууллагад 148,264.6 сая төгрөгийн хохирол учирч, гэмт хэргийн халдлагад 27475 иргэн өртсөн бол 2013 онд хохирсон иргэдийн тоо 25015 байсан байна.<sup>136</sup>

Гэмт хэрэг үйлдэгсдийн дунд урьд хорих ял эдлээд суллагдсан хүмүүс бага бус хувийг эзэлж байгаагийн зэрэгцээ, энэ үзүүлэлт жил бүр өсөх хандлагатай буюу 2013 онд 909, 2014 онд 1101 байгаа нь 21.1 хувиар өссөн байна.<sup>137</sup>

### Хорих ял эдлүүлэх ажиллагааны талаар

Монгол Улсад хорих ял эдэлж байгаа хүний тоог хүн амын тоон үзүүлэлттэй харьцуулж авч үзвэл дэлхийн бусад орнуудтай

харьцуулахад харьцангуй өндөр үзүүлэлттэй буюу 100.000 хүн ам тутамд 220 орчим ялтан ноогдож байна. Хорих ял эдлэгсдийн тоо өссөн, хорих газраас суллагдаад дахин гэмт хэрэг үйлдэх явдал буурахгүй байгаа зэрэг нь ял эдлүүлэх ажиллагааны талаар баримтлах бодлогыг шинэчлэх шаардлагыг бий болгож байна.

Өнөөдрийн байдлаар улсын хэмжээнд 25 хорих ангид 6500 орчим ялтан ял эдэлж байна. Үүнээс гяндан буюу хорих өрөөний системтэй, хөдөлгөөний хатуу хязгаарлалт бүхий хорих ангид 70-90 ялтан, онцгой дэглэмд буюу хөдөлмөрлөх цаг, бусад эрхийн хязгаарлалт өндөр бүхий хорих ангид 300 орчим, чанга дэглэмд 2600-2700, жирийн дэглэм бүхий хорих ангид 3400 орчим, баривчлах ял эдлүүлэх ангид 170 орчим ялтан ял эдэлж байна. Үүнээс эмэгтэйчүүдийн хорих ангид 350 орчим ялтан, насанд хүрээгүйчүүдийн хорих 30 орчим ялтан ял эдэлж байна.<sup>138</sup>

Өнөөдрийн байдлаар хорих ялын үр нөлөөг дээшлүүлэх явдал хурцаар тавигдаж байгаа бөгөөд энэ нь ялтныг нийгэмшүүлэх бодлогыг илүү өргөн хүрээтэйгээр хэрэгжүүлэх шаардлагыг бий болгож байна. Хорих ял эдлэгсдийг нийгэмшүүлэх ажлын хүрээнд дараах арга хэмжээнүүдийг багтаан ойлгож болох юм. Үүнд:

- Хорих ял эдлэгсдийг хөдөлмөрлүүлэх.
- Хорих ял эдлэгсдийг нийгэм, сэтгэл зүйн үйлчилгээн, хамруулах.
- Хорих ял эдлэгсдийн дунд төрөл бүрийн сургалт зохион байгуулах, чадваржуулах.

<sup>136</sup> <http://www.police.gov.mn/news/content/id/993/type/18/menuid/11> 2015.04.20

<sup>137</sup> [http://www.police.gov.mn/media/Statistic\\_medee/2014.12\\_sar\\_medee/2014.12\\_Gemt\\_hereg\\_uildegsed.pdf](http://www.police.gov.mn/media/Statistic_medee/2014.12_sar_medee/2014.12_Gemt_hereg_uildegsed.pdf) 2015.04.20



<sup>138</sup> ШШГЕГ-ын 2015 оны 3 дугаар сарын албаны статистик мэдээнээс...

- Хорих ял эдлэгсдийг урлаг, спорт, авьяас, сонирхол, шүтлэг, зан үйл зэрэг нөлөөллийн арга хэмжээгээр дамжуулан хөгжүүлэх.
- Хорих ял эдлэгсдийг гэр бүл, төрийн бус байгууллага, олон нийтийн дунд оруулан зан үйлийг төлөвшүүлэх.
- Хорих ял эдлэгсдийг суллагадахад бэлтгэх.

хүрээнд нийгмээс тусгаарлах бус суллагдсаны дараа дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, нийгмийн амьдралд дасан

зохицох чадвар суулгах буюу нийгэмшүүлэхэд гол анхаарлаа хандуулж байна.

Нийт ял эдлэгсдийн дунд урьд нь гэмт хэрэг үйлдэж хорих ял шийтгэгдэж байсан ялтны эзлэх хувийг



### 1-р зураг. Хорих ял эдлэгсдийн тоон үзүүлэлт


#### Хорих байгууллагаас суллагадгсдыг нийгэмшүүлэх шаардлага

Хорих ангиас суллагдсан хүн нийгмийн харилцаанд оролцох чадваргүйн улмаас дахин гэмт хэрэг үйлдэж, улмаар “шоронжсон” буюу гэмт хэрэг үйлдэн хорих ялаар удаа дараа шийтгүүлэх амьдралын хэв маяг бүхий хүмүүсийн тоо өсөх хандлагатай байна. Дэлхийн бусад улс орнуудын жишигээс авч үзвэл хорих ял эдлүүлэх ажиллагаа нь зөвхөн шүүхийн шийтгэх тогтоолын

судалж үзэхэд нийт ялтны дунд эзлэх хувь нь 51-54%, харин чанга буюу түүнээс дээш дэглэмийн хорих ангид ял эдлэгсэдийн 75 орчим хувь нь урьд нь хорих ялаар 1-8 удаа шийтгэгдэж байсан тоон үзүүлэлт гарч байгаа ба хатуу буюу уян хатан бус нөхцөл, хязгаарлалттай дэглэмд хорих нь ялтныг аажмаар шоронжих замаар гэмт аргаар амьдрах зам руу хөтөлж байгаа нь судалгаанаас харагдаж байна.

2013-2014 онуудад бүх төрлийн дэглэмийн хорих ангийг хамруулан хэсэгчилсэн судалгаа хийж үзэхэд боловсролын ямар нэг түвшинд

суралцаж байгаагүй ялтан 6%, бүрэн дунд, бүрэн боловсролын сургалтанд хамрагдсан буюу хагас хамрагдсан ялтан 81%, бакалаврын сургалтанд хамрагдсан ялтан 13%, мэргэжилгүй ялтан 69%, мэргэжлийн ямар нэг сургалтанд хамрагдсан ялтан 22%, хорих ангид ял эдэлж байхдаа мэргэжлийн сургалтанд хамрагдсан ялтан 9% байсан байна.



- Ажил хийх сонирхолгүй, надад хэрэг хийхээс өөр чадах юм юу байхав.
- Ажил хийе гэвч мэргэжил байхгүй.
- Амьдрах тогтсон орон байр, харьяалал байхгүй.
- Хуучин хамт ял эдэлж байсан, хэсүүчилдэг, архиддаг хүмүүстэй нийлээд гэмт хэрэг үйлдсэн.
- Амьдралын аргагүйн эрхэнд буюу хоол, хувцас, мөнгө олохын тулд.

■ Боловсролгүй

■ Ерөнхий боловсролын сургалтанд тодорхой хэмжээгээр хамрагдсан Мэргэжлийн сургалтанд хамрагдаж байсан

**2-р зураг. Хорих ял эдлэгсдийн боловсрол, мэргэжлийн судалгаа /бүх төрлийн дэглэмийн хорих ангийг хамруулан 1000 ялтнаар хэсэгчилэн авав/.**

Хорих байгууллагаас суллагдаад дахин гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлсэн 300 ялтны дунд фокус ярилцлагын арга ашиглан судалгаа явуулж үзэхэд дараах нийтлэг шалтгаан буюу хүндрэлийн улмаас дахин гэмт хэрэг үйлдсэн талаар асуулгад оролцогсод хариулжээ. Үүнд:

- Удаан хугацаагаар хорих ял эдэлсэн учраас эрх чөлөөт нийгмийн амьдралд дасахгүй байна.
- Сайхан амьдрах мөрөөдөлтэй байсан боловч хүлээж авах, тусалж дэмжих төрөл садан, найз нөхөд байхгүй. /Эхнэр салсан/
- Ажил хайгаад олоогүй.
- Ажилд орох гэсэн боловч шоронд байсан гээд хэн ч аваагүй.

- Бусдаас өш хонзон авах зорилгоор.
- Тохиолдлоор...

#### ДҮГНЭЛТ:

Дээрх бүгдээс үзвэл хорих байгууллагаас суллагдасгдын хувьд нийгмийн тодорхой байр суурьгүй, ажил эрхлэлт муу, тодорхой орлогын эх үүсвэргүй, боловсролын түвшин хангалтгүй, суллагдаад нийгмийн харилцаанд ухамсартайгаар оролцох чадваргүйгээр дахин гэмт хэрэг үйлдэн ял шийтгэгдэж байгаа дүгнэлт гарч байна. Өөрөөр хэлбэл ялын бодлогод дорвитой өөрчлөлт хийхийн зэрэгцээ суллдагдагсдад чиглэсэн эрх зүйн зохицуулалтыг хүн ба нийгмийн хөгжилийн дэмжихэд чиглэсэн байдлаар өөрчлөх шаардлага бий болсоныг харуулж байна.

#### САНАЛ:

1. Хорих ял эдлүүлэх бодлого, тогтолцоо, нөхцөл зэргийг гадаад улс орнуудын болон өөрийн орны онцлогт

нийцүүлэн ял эдлэгсдийг нийгэмшүүлэхэд чиглэсэн байдлаар хөгжүүлэн өөрчлөх.

2. Өнөөдрийн үйлчилж буй Эрүүгийн хуулийн өөрчлөлтийг боловсруулахдаа хорихоос өөр төрлийн ялыг хувь хүний онцлогт тохирсон байдлаар түлхүү хэрэглэх нөхцлийг бүрдүүлэх.

3. Хорих ял эдлэгсдийг суллагдахын өмнөх цогц нөлөөлийн болон чадавхижуулах сургалт, бусад нийгэмд дасан зохицох арга хэмжээнд хамруулах ажлыг хөгжүүлэх, энэ талаар эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох.

4. Хорих байгууллагаас суллагдсан иргэнийг нийгэмшүүлэх бие даасан эрх зүйн зохицуулалт, төрийн салбар институцийг бий болгон хөгжүүлэх.

Энэхүү саналын хүрээнд та бүхэнд олон улсын хэллэгээр пробаци гэж тогтсон ойлголтын талаар товч мэдээллийг хүргэе.

**Пробаци** гэсэн нэр томъёо нь **probatio** гэсэн латин үгнээс гаралтай ба энэ нь оросоор испытания, монголоор туршилт хэмээн орчуулагдаж байна.

Пробацийн үйл ажиллагааг хорих ял эдлүүлэх үйл ажиллагааны явцад ялтныг гэмт хэрэгтэн бие хүн болж өөрчлөгдөхөөс урьдчилан сэргийлэх, улмаар нийгмийн харилцаанаас тусгаарлахгүйгээр гэмт зан үйлийг өөрчлөх, нийгмийн амьдралд дасан зохицуулан дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор европын улс орнуудад 19 дүгээр зууны сүүлчээр нэвтрүүлж эхэлжээ.

Тодруулбал анх 1872 онд Лондонд, 1985 онд Римд, 1889 онд

Брюсселд олон улсын хорих байгууллагуудын их хурал дээр хорих ялыг урт хугацаагаар бус харин хяналтын өөр хэлбэрээр хэрэглэх хэлбэрээр хэлэлцэж, Англи, Бельги, АНУ-д 1887-1930-д оны хооронд хэрэгжүүлэн хөгжүүлж иржээ.

1990-д оноос хойш хуучин социалист тогтолцоо бүхий улс орнуудад үүссэн нэг хүндрэл нь хорих ял эдлэгсдийн тоо их, түүнд гарах төсвийн зардал их байсны зэрэгцээ, шоронжсон буюу гэмт зан авир, төлөвшил бүхий нийгмийн давхарга, томоохон бүлэг хүмүүс гарч ирсэн явдал юм. Тиймээс гэмт хэрэг үйлдсэн хүмүүсийг шоронжуулахгүй байх, дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор тухайн улс орнууд европын улс орнуудаас пробацийн албаны үйл ажиллагааг нэвтрүүлж эхэлсэн байдаг.

Дэлхийн улс орнуудад хэдийгээр пробацийн албаны талаар нэгдсэн нэг, тогтсон ойлголт байхгүй хэдий ч явуулж байгаа үйл ажиллагаа, зорилго, ач холбогдолын хувьд ижил төстэй байдлаар хөгжиж ирсэн.

Нийтлэг байдлаар буюу гадаад улс орнуудад хэрэгжүүлж буй байдлаас авч үзвэл авч үзвэл пробацийн албаны **гол зорилго нь:**

- Гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлсэн этгээдийг нийгмийн харилцаа, орчноос тусгаарлахгүй байх.
- Гэмт хэрэг үйлдсэн хүнийг дахин гэмт хэрэг үйлдэх зан үйлээс татгалзуулах, урьдчилан сэргийлэх.
- Гэмт хэрэг үйлдсэн хүнийг нийгмийн зохист амьдралд ороход тусалцаа үзүүлэх.
- Гэмт хэрэг үйлдсэн хүний хууль сахин биелүүлэх, бусадтай зөв харилцаанд

орох чадварт сургах, хөгжүүлэх явдал юм.

Пробацийн албаны үйл ажиллагааг хэрэгжүүлж буй олон улсын практикаас үзвэл чиглэл болон агуулга нь дараах хэлбэртэй байна. Үүнд:

- Тэнсэн харгалзах ял шийтгэгдсэн этгээдэд тавих хяналт./Англи, АНУ, Латви, Швед г.м/
  - Албадан хөдөлмөрлүүлэх ялын хэлбэрээр./мөн дээрх улсууд, Финлянд, Япон/
  - Хорих ял хойшлуулсан бөгөөд шүүхээс тодорхой төрлийн эрхийн хязгаарлалт тогтоосон.
  - Гэрийн хорионд байлгах ялын хэлбэрээр./ОХУ, Канад г.м/
  - Хорих газраас суллагдсан хүмүүст нийгмийн амьдралд ороход туслалцаа үзүүлэх, нийгэмшүүлэх. /Дангаар Эстони, хамтатган дээрх орнууд/
  - Насанд хүрээгүй этгээд гэмт хэрэгт холбогдсон тохиолдолд.
  - Гэмт хэрэгт шалгагдаж байгаа хүнд туслалцаа үзүүлэх./Молдав г.м/
  - Гэмт хэрэг үйлдсэн хүнийг хохирогчтой эвлэрүүлэх, зуучлах./Молдав, Латви/
- Дээрх бүгдээс жишээ болгон Латви улсын пробацийн албан үндсэн чиг үүргийг авч үзье.
- Хяналтанд орсон хүний талаарх бүхий л мэдээллийг багтаасан урьдчилсан илтгэл бэлтгэх. Энэ нь шүүх болон хууль хяналтын байгууллагад, түүнчлэн тухайн хүнд чиглэсэн бусад хөтөлбөрийг боловсруулахад ашиглагдана.
  - Хяналтанд орсон хүнийг дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, зан үйлийг засах хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх.

- Албадан ажил хийлгэх ялыг хэрэгжүүлэх.

- Насанд хүрээгүй этгээдийн талаар шүүхээс гаргасан хязгаарлалтын шийдвэрийг хэрэгжүүлэх.

- Эрүүгийн хэрэг түдгэлзсэн этгээдэд түршилтын хугацаа тогтоосон шүүхийн шийдвэрийг хэрэгжүүлэх.

- Хорих байгууллагатай суллагдахад бэлтгэх талаар хамтран ажиллах.

- Тэнсэн харгалзсан болон хугацааны өмнө тэнсэн суллагдсан этгээдэд хяналт тавих.

- Хорих байгууллагаас суллагдсан этгээдэд туслалцаа үзүүлэх.

Эндээс зөвхөн хорих байгууллагаас суллагдсан этгээдэд чиглэсэн үйл ажиллагааны чиглэлээр:

- Суллагдах хүнийг урьдчилан судалгаанд авах.

- Тухайн хүнийг судласаны дараа түүнтэй бичгээр хэлцэл байгуулах.

- Ял эдлэх үеийн бүхий л зан төлөв, хувийн байдлыг үндэслэн зан үйлийг төлөвшүүлэх хөтөлбөр боловсруулах.

- Орон байргүй тохиолдолд түр амьдрах байранд зуучлах, мэдээлэл өгөх.

- Төрийн бусад байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллага, төрийн бус байгууллагатай суллагдсдыг нийгэмшүүлэх талаар хамтран ажиллах.

- Хэрэгцээт мэргэжлийн сургалтанд хамрагдах, түүнийг олж сонгоход туслалцаа үзүүлэх.

- Хувийн бичиг баримттай болоход туслах.

- Түүнийг нийгэмшүүлэх зорилго бүхий тодорхой туршилтийн хөтөлбөрт хамруулах санал тавих.